

Огноо: 2023.01.12

**УЛААНГОМ СУМЫН ЗДТГ-Т ШАТАХ ТОСЛОХ
МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН
САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалт/
гэрээний нэр: **Улаангом сумын ЗДТГ-т ШТМ-л нийлүүлэх**

Тендер шалгаруулалт/
гэрээний дугаар: **УВАУГСЗДТГ/202301062**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Улаангом сумын ЗДТГ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Улаангом сумын ЗДТГ-т шатах тослох материал нийлүүлэх ажил”-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг **2023 оны 01-р сарын 24-ний өдрийн 10:00 цаг /орон нутгийн цагаар 09:00/-**аас өмнө www.tender.gov.mn хаягаар цахимаар ирүүлнэ.

Тендерийн баримт бичиг, ажлын даалгавар болон бусад бичиг баримтыг www.tender.gov.mn хаягаар орж үнэгүй татаж авна уу.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2023 оны 01-р сарын 24-ний өдрийн 11:00 цаг /орон нутгийн цагаар 10:00/-**т нээнэ.

Хаяг: Улаангом сум 11-р баг

Утас:70452124

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо :2023.01.12

Тендер шалгаруулалтын нэр: Увс аймгийн Улаангом ЗДТГ бензин, шатахуун , дизель түлш тос тослох материал нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: **УВАУГСЗДТГ/202301062**

Улаангом сумын ЗДТГ-нь эрх бүхий тендерт оролцогчдоос Улаангом сумын ЗДТГ-т бензин, шатахуун , дизель түлш, тос тослох материал нийлүүлэх үнийн санал ирүүлэхийг урьж байна.

- 1.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
- (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан -2021 он
 - (г) Туршлагын мэдээлэл, гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар болон бусад баримт бичиг ирүүлнэ;
 - (д) Шаардлагатай тусгай зөвшөөрөл: Барааны гарал үүслийн гэрчилгээтэй байна. Стандарт хэмжил зүйгээр баталгаажсан байна.

Тендерийг 2023 оны 01-р сарын 24-ний өдрийн 10 цаг 00 минут /орон нутгийн цагаар 09:00/ –аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2023 оны 01-р сарын 24-ний өдрийн 11 цаг /орон нутгийн цагаар 10:00/-т нээнэ.

Увс аймаг Улаангом сумын ЗДТГ-ын байр

2-р давхар 206 тоот өрөө

Утас 70452124

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | | |
|---|------|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 3.1. | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. |
| | 3.2. | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 4.1. | Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан 2021 - аудитаар баталгаажсан, туршлагын мэдээлэл, гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг ирүүлнэ;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл; Барааны гарал үүслийн гэрчилгээтэй байна. Стандарт хэмжил зүйгээр баталгаажсан байна.
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. | Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. |
| | 5.2. | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. | Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 5 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

- | | |
|--|---|
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | <p>7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.</p> <p>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.</p> <p>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.</p> |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | <p>8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.</p> |

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШӨХ-ийн холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТШӨХ 1.1	Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлсөн эсэх мэдэгдэл, татварын тодорхойлолтын хамт ирүүлнэ. /татварын өртэй бол энэ нь тус тендерээс татгалзах үндэслэл болно/.
ТШӨХ 1.2	<ul style="list-style-type: none"> - Төсөвт өртөг: 59,087,500/тавин есөн сая наян долоон мянга таван зуун/ төгрөг. - Санхүүжих эх үүсвэр:Улаангом сумын орон нутгийн төсөв. - Үнийн санал ирүүлнэ. - Шатахуун импортлох зөвшөөрөл. - Үйлдвэрлэл, борлуулалт эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх. - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар ирүүлнэ. - Гарал үүслийн бичиг /бүтээгдэхүүний тодорхойлолт/ - Барааны чанарын дүгнэлт /Стандарт хэмжилзүйн газрын/. - Гэрээ гүйцэтгэх зайлшгүй шаардлагатай ШТС-ын байршлын жагсаалт.
ТШӨХ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Тендерт оролцогчид тендерийн материалыг цахимаар 2023 оны 01-р сарын 24-ний өдөр 10 цаг 00 /орон нутгийн цагаар 09 цаг 00/ минутаас өмнө илгээнэ.</p>
ТШӨХ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь:</p> <p>Нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2023 оны 01-р сарын 24-ний өдөр 11 цаг 00 /орон нутгийн цагаар 10 цаг 00/ минутад Увс аймаг, Улаангом сум 11-р баг, Сумын ЗДТГ-ын байр, 206 тоот өрөөнд нээнэ.</p>
ТШӨХ 3.1	<ul style="list-style-type: none"> - Хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэх эрх авсан ижил төстэй гэрээний талаарх мэдээллийг ирүүлнэ. - Материал татан авалтын хуваарийг ирүүлнэ. - 2021 оны борлуулалтын орлогын дундаж мөнгөн дүн төсөвт өртгийн 50% буюу 29,6 сая төгрөгөөс багагүй байна. - 2021 оны санхүүгийн тайланг харьяа аймаг дүүргийн СТСХэлтсээр баталгаажуулан аудитын дүгнэлтийн хамт

	ирүүлнэ.
ТШӨХ 4.1	Үнийн саналд өгөгдсөн ажлын тоо хэмжээнд тусгагдсан нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
ТШӨХ 4.4	Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
ТШӨХ 5.1	Үнийн санал нь тендер нээснээс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
ТШӨХ 7.1	Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
ТШӨХ 7.2	Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барааны тодорхойлолт: Техникийн тодорхойлолт болон зураг

Увс аймгийн Улаангом сумын ЗДТГ-ын хэрэгцээнд зориулан нийлүүлэх бензин, шатахуун, тос тослох материалын техникийн тодорхойлолт болон шаардлага, үзүүлэлтүүд /стандарт/

Шатахууны нэр: ОХУ-д үйлдвэрлэсэн, эсвэл түүнтэй дүйцэхүйц дотоод шаталтат хөдөлгүүрийн түлш, автобензин.

Техникийн шаардлага MNS 217-2006

Д/д	Үзүүлэлтүүдийн нэр	Үзүүлэлт тус бүрийн хэмжээ		Шинжилгээний аргууд
		А-80	АИ-92	
1	Моторын аргаар тодорхойлсон октаны тоо, багагүй	76	83	ГОСТ 511
2	Шинжилгээний аргаар тодорхойлсон октаны тоо, багагүй	80	92	ГОСТ 8226
3	1 дм ³ бензин дэх хартугалганы хэмжээ грамм, ихгүй	0,010		MNS335-1983
4	1 дм ³ бензин дэх марганецын агуулга мг, ихгүй	50	-	
5	100 см ³ бензинд нэгдэх бодит давирхайн хэмжээ мг, ихгүй	5,0		MNS 477-1996
6	Бензиний индукцийн үе мин, багагүй	360		ГОСТ 4039
7	Бензиний нэгж масст ногдох хүхрийн хэмжээ хувь, ихгүй	0,05		MNS 470-1980
8	Нэгж эзэлхүүнд ногдох бензолын хэмжээ, хувь ихгүй	5		ГОСТ 29040
9	Зэс хавтгайн туршилт	тэсвэртэй	тэсвэртэй	MNS 326-2005
10	Өнгө, гадна төрх	Тунгалаг, цэвэрхэн		
11	15 ⁰ С дахь хувийн жин	700-750	725-780	ГОСТ 51069-97

Автобензиний уурших чанарын үзүүлэлтүүд

Д/д	Үзүүлэлтүүдийн нэр	Үзүүлэлт тус бүрийн хэмжээ		Шинжилгээний аргууд
		Зун	Өвөл	
1	Ханасан уурын даралт, Кпа -Хамгийн бага -Хамгийн их	35 70	35 79,9	MNS 3626-1983
2	Найрлагын бүрэлдэхүүн ⁰ С			MNS 3405-2000

	А. Буцалж эхлэх температур, доошгүй	35	нормчлогдохгүй	
	Б. 10%-ийн нэрэгдэх температур, дээшгүй	75	55	
	В. 50%-ийн нэрэгдэх температур, дээшгүй	120	100	
	Г. 90%-ийн нэрэгдэх температур, дээшгүй	190	160	
	Д. Буцалж дуусах температур, дээшгүй	215		
	Е. Колбо дахь үлдэгдэл эзэлхүүний хувь, ихгүй	2,0		
3	Ууршилтын индекс, ихгүй	900	1300	

Шатахууны нэр:

Дотоод шаталтат хөдөлгүүрийн түлш дизелийн түлш.

Техникийн шаардлага MNS 216-2006

Д/д	Үзүүлэлтүүдийн нэр	Үзүүлэлт тус бүрийн хэмжээ		Шинжилгээний аргууд
		Зун	Өвөл	
1	Цетаны тоо, багагүй	45	45	MNS 229-1960
2	Найрлагын бүрэлдэхүүн °C, дээшгүй - 50%-ийн нэрэгдэх температур, - 96%-ийн нэрэгдэх температур (нэрэгдэж дуусах)	280 360	280 340	MNS 3405-2000
3	20°C градус дахь кинематик зууралдлага, мм ² /сек (сСт)	3-6	1,8-5	MNS 480-1980
4	Царцах температур дээшгүй, - Сэрүүн бүсэд - Хүйтэн бүсэд	-10 -	-35 -45	MNS 3192-1996
5	Булингартах температур дээшгүй, - Сэрүүн бүсэд - Хүйтэн бүсэд	-5 -	-25 -35	MNS 3594-1983
6	Битүү тагшинд тодорхойлсон дүрсхийн асах температур, доошгүй	40	35	MNS 333-1983
7	Нийт хүхрийн хэмжээ, хувь ихгүй	0,2	0,2	MNS 337-1983
8	Меркаптаны нийт хүхрийн хэмжээ, хувь ихгүй	0,01	0,01	MNS 3627-1983
9	Зэс хавтгайн туршилт	тэсвэртэй	тэсвэртэй	MNS 326-2005
10	Усанд уусдаг хүчил шүлтийн хэмжээ, хувь ихгүй	байхгүй	байхгүй	MNS 3624-1983
11	100 см ³ бензинд нэгдэх бодит давирхайн хэмжээ мг, ихгүй	40	30	MNS 477-1996

12	Хүчиллэг чанар, 100 см ³ түлшинд нэгдэх КОН-ийн хэмжээ, мг ихгүй	5	5	MNS 334-1996
13	Иодын тоо 100 г түлшинд грамм нэгдэх иодын хэмжээ грамм, ихгүй	6	6	MNS 3500-1983
14	Үнслэг хувь, ихгүй	0,01	0,01	MNS 3501-1983
15	10%-ийн үлдэгдлийн коксжилт хувь, ихгүй	0,30	0,30	MNS 336-1983
16	Механик хольцын хэмжээ, %	байхгүй	байхгүй	MNS 3697-1983
17	Усны хэмжээ, %	байхгүй	байхгүй	MNS 332-1996
18	20 ⁰ С градус дахь хувийн жин кг/м ³ ихгүй	860	840	MNS 481-1988

Жич: Шатахууны чанарын паспортыг дагалдуулах ба нийлүүлэгч нь захиалагчид хүлээлгэн өгөхдөө нийлүүлэгчийн тодорхой хаяг, гарын үсэг бүхий мэдээллийг баримт бичигт тодорхой оруулж бичнэ.

1. Стандарт: Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.] гэж бичнэ
2. Баглаа, боодол: [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]
3. Бараа хүргэх газар: Увс аймгийн Улаангом сум ЗДТГ
4. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
А-80 А-92 Дизель түлш Тос тослох материал	Монгол улсад мөрдөгдөж буй стандартыг хангасан байна.		тонн	Увс аймгийн Улаангом ЗДТГ	2023 оны 02 сарын 01	2024 оны 1 сарын 31	

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

**2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО
ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа **[тоо]** жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш **[ГТН-д заасан тоо]** хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1) 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5) 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. Төлбөр (ГЕН – 7) 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **[moo]**¹хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)² 9.1. Алданги оногдуулах хувь: **[moo]**
- Алдангийн нийт дүн: **[moo]**

¹Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнө.

² Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.